



ТӨВ АЙМАГ
БҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/95

Бүрэн сум

Хорио цээрийн дэглэм цуцлан
хязгаарлалтын дэглэмд шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.23 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.2.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.1, 18.3, 18.4 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Монгол (3-р) багийн нутаг Улаан-Овоо гэдэг газарт тогтоосон шүхий өвчний хорио цээрийн дэглэмийн хугацаа дууссантай холбогдуулан 2021 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаатай хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2. Хязгаарлалт тогтоосон бүсээс гарах мал амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд тээвэрлэж, байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хориглосугай.

3. Хорио цээрийн дэглэмийг цуцалсантай холбоотойгоор сумын Засаг даргын 2021 оны А/82 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (С. Дагвадорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



БОТГОНХИШИГТ

410500251